



2020 оны 12 дугаар сарын 25
№48 /1150/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

ᠲᠦ᠋ᠷᠢᠢᠨ
ᠮᠡᠳᠡᠭᠡᠯᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯ

ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠶ᠋ᠢᠬᠡ ᠬᠤᠷᠤᠯ
ᠠᠯᠪᠠᠨ ᠮᠡᠳᠡᠭᠡᠯ



זינגסאג

זערטעג באיאגן פון יענען

79102	קענישן 9	זינגען דאן ארויף אפגעבן און אריבערגעבן זינגן זינגערס אפגעבן פון ארויף אפגעבן זינגן	• 79102 • 79101 • 90101
62107	קענישן 6	זינגערס, זינגערס, ארויף, ארויף דאן אריבערגעבן פון זינגען פון אריבערגעבן דאן זינגן ארויף פון זינגערס, אריבערגעבן זינגן	• 10101
72107	קענישן 7	זערטעג באיאגן פון אריבערגעבן זינגן פון זינגערס אריבערגעבן זינגערס אריבערגעבן זינגן	• 90101
90107	קענישן 9	« אריבערגעבן זינגערס (אריבערגעבן - 90) » דאן זינגן זינגערס אריבערגעבן אריבערגעבן, אריבערגעבן, אריבערגעבן, אריבערגעבן זינגערס אריבערגעבן זינגן אריבערגעבן זינגן אריבערגעבן זינגערס אריבערגעבן זינגן »	• 90101
72107	קענישן 7	אריבערגעבן זינגערס אריבערגעבן זינגן פון זינגערס אריבערגעבן זינגן אריבערגעבן זינגערס אריבערגעבן זינגן	• 90101 • 70101
07107	קענישן 7	אריבערגעבן זינגערס אריבערגעבן זינגן פון זינגערס אריבערגעבן זינגן אריבערגעבן זינגערס אריבערגעבן זינגן	• 90101
107107	קענישן 10	זערטעג באיאגן פון זינגערס אריבערגעבן זינגן אריבערגעבן זינגערס אריבערגעבן זינגן	• 90101



ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

502.	Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай	2567
503.	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай	2569
504.	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	2571
505.	Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	2573

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

506.	“Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар чиглэл өгөх тухай”	Дугаар 36	2574
507.	Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай	Дугаар 37	2578
508.	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 39	2580

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

509.	Журам шинэчлэн батлах тухай	Дугаар 133	2585
------	-----------------------------	------------	------

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 дугаар
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

ГААЛИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын урьдчилан төсөөлөх боломжгүй нөхцөлд хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, ургамлын тос болон 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй давахад шаардагдах мал, амьтны бүх төрлийн тэжээл, өвс, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосыг импортлоход гаалийн албан татвараас тус тус чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл.Гаалийн албан татвараас чөлөөлөх бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, ургамлын тос, мал, амьтны бүх төрлийн тэжээл, өвс, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосны жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 дугаар
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын урьдчилан төсөөлөх боломжгүй нөхцөлд хүнсний хангамжийн тогтвортой байдлыг хангах зорилгоор бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, ургамлын тос болон 2020-2021 оны өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй давахад шаардагдах мал, амьтны бүх төрлийн тэжээл, өвс, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосыг импортлоход, түүнчлэн Монгол Улсын нутаг дэвсгэрт боловсруулсан ургамлын тос, дотоодод борлуулсан мал, амьтны бүх төрлийн тэжээл, өвс, бүх төрлийн хүнсний будааг /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/ нэмэгдсэн өртгийн албан татвараас тус тус чөлөөлсүгэй.

2 дугаар зүйл.Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх бүх төрлийн хүнсний будаа /цагаан будаа, гурвалжин будаа, шар будаа, бусад/, ургамлын тос, мал, амьтны бүх төрлийн тэжээл, өвс, тэжээлийн үр, хүнсний улаанбуудай, улаанбуудайн үр, тослог ургамал, ургамлын түүхий тосны жагсаалтыг “Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем /БТКУС/”-ийн ангиллын дагуу Монгол Улсын Засгийн газар батална.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрөөс 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 дугаар
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 5.3 дахь хэсэг нэмсүгэй:

“5.3. Ээлжит бус, нөхөн, дахин сонгуульд 18 нас хүрсэн, тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт санал авах өдрөөс 180-аас доошгүй хоногийн өмнө шилжин суурьшиж, байнга оршин суугчаар бүртгүүлсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан иргэн тухайн шатны Хурлын Төлөөлөгчөөр сонгогдох эрхтэй.”

2 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“5.2. 18 нас хүрсэн, ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэгт шилжин суурьшиж, байнга оршин суугчаар бүртгүүлсэн, сонгуулийн эрх бүхий, энэ хуульд заасан бусад шаардлагыг хангасан иргэн тухайн шатны Хурлын Төлөөлөгчөөр сонгогдох эрхтэй.”

3 дугаар зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3, 5.4 дэх хэсгийн дугаарыг “5.4, 5.5” гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 12 дугаар
сарын 04-ний өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “02 дугаар сарын 01-ний өдрөөс” гэснийг “02 дугаар сарын 15-ны өдрөөс” гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

Үсэнтэйг бичгээр мэдэгдсэн

Мэргэжлийн гүйцэтгэл

2020 оны 12 сарын 04 өдөр /12 сарын 04 өдөр/

Мэргэжлийн гүйцэтгэл мэдэгдсэн
Мэргэжлийн гүйцэтгэл мэдэгдсэн

6 сарын өдөр, үсэнтэйг бичгээр мэдэгдсэн
Мэргэжлийн гүйцэтгэл мэдэгдсэн
Мэргэжлийн гүйцэтгэл мэдэгдсэн
Мэргэжлийн гүйцэтгэл мэдэгдсэн
Мэргэжлийн гүйцэтгэл мэдэгдсэн

Мэргэжлийн гүйцэтгэл

Мэргэжлийн гүйцэтгэл

Мэргэжлийн гүйцэтгэл



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 36

Улаанбаатар
хот

“Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар чиглэл өгөх тухай”

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Коронавируст халдвар /КОВИД-19/ цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, өвчлөлийн цар хүрээ нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад тулгарах хүндрэлийг хохирол багатай даван туулах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:

1/Гамшгаас хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хуулиудад өөрчлөлт оруулах, цар тахлын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр тодорхой асуудлыг шийдвэрлүүлэх саналаа Улсын Их Хуралд танилцуулах;

2/иргэдийн эрүүл мэндэд учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулж удирдлагаар хангахыг Эрүүл мэндийн сайдад үүрэг болгох;

3/коронавируст халдвар /КОВИД-19/-ын эмчилгээ, оношилгооны төвийг бүсчилсэн хэлбэрээр аймаг орон нутагт байгуулж, оношлуурын багаж, тоног төхөөрөмжөөр /PCR/ хангах;

4/орон нутгийн сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан аймаг, сумдын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг хийж, Засаг дарга нарыг томилох асуудлыг шуурхайлах;

5/Малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн хугацааг хойшлуулах асуудлыг судалж, санал боловсруулан Улсын Их Хуралд танилцуулах;

6/коронавируст халдвар /КОВИД-19/-ын вакциныг эхний ээлжид худалдан авах чиглэлээр олон улсын холбогдох байгууллагуудтай гэрээ хэлэлцээр байгуулах;

7/иргэд, олон нийтэд хувийн ариун цэврийг сахиж, хариуцлагатай байх, бусдын эрхийг хүндэтгэх талаарх мэдээлэл, сурталчилгааг идэвхжүүлэх;

8/Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэх хугацааг сунгах эсэх тухай саналаа Улсын Их Хурал /Түр хороо/-д танилцуулж, шийдвэрлүүлэх.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороод болон Улсын Их Хурлын Түр хороо /Б.Баттөмөр/-нд даалгасугай.

3.Энэ тогтоолыг баталсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 12 дугаар
сарын 03-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар
хот

Хүний эрхийн дэд хорооны бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуягийг Хүний эрхийн дэд хорооны гишүүнээр баталсугай.

2.Энэ тогтоолыг 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 12 дугаар
сарын 04-ний өдөр

Дугаар 39

Улаанбаатар
хот

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:

1/бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн сахилга бат, хариуцлагыг дээшлүүлэхэд тавих хяналтыг сайжруулж, төсвийн орлого нэмэгдүүлэх, зарцуулалтын үр ашгийг дээшлүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж, бүх салбарын төсвийн шинэчлэлийг эрчимжүүлэх;

2/төсвийн ерөнхийлөн захирагчдын жилийн төсвийн гүйцэтгэл, үр дүнд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой шийдвэр гарган, хэрэгжилтийг хангаж ажиллах;

3/нийгмийн халамжийн хамрах хүрээг оновчтой болгож, төрийн зүгээс тусламж, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлэгт чиглүүлэх, олон төрлийн хөтөлбөр, арга хэмжээг нэгтгэх, зарим үйлчилгээг бусад салбарт шилжүүлэх замаар давхардлыг арилган халамжийн үр дүнтэй тогтолцоог нэвтрүүлэх чиглэлээр Нийгмийн халамжийн багц хуулийн төслийг Улсын Их Хурлын 2020 оны намрын ээлжит чуулганы хугацаанд өргөн мэдүүлэх;

4/Монгол Улсын 2021 оны төсвийн төслөөс хасагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдийн нийгмийн ач холбогдол, эдийн засгийн үр ашгийг тооцон эрэмбэлж, төсвийн тухай хууль тогтоомжийн шаардлагад нийцүүлэн дараа оны төсвийн төсөлд тусгах асуудлыг шийдвэрлэх;

5/төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрын нүхэн жорлонг орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын санхүүжилтийг “Эрдэнэт”



ТӨҮГ-аар нийгмийн хариуцлагын хүрээнд шийдвэрлүүлэн 2021-2022 онд багтаан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

6/аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээг хагас бие даасан удирдлагын тогтолцоонд шилжүүлж байгаатай холбогдуулан төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагын боловсон хүчнийг чадавхжуулах, тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад шаардагдах багаж, тоног төхөөрөмжийг худалдан авах зардлыг 2021 онд Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгөөс санхүүжүүлэх.

2.Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Б.Жавхлан/-нд даалгасугай:

1/төсвийн шинэчлэлийг бүх түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг боловсруулан Улсын Их Хурлаар батлуулж, төсвийн шинэчлэлийг өргөн хүрээнд эрчимжүүлэх, бодлогын удирдамжаар хангах, хяналт тавих ажлыг зохион байгуулах;

2/төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагч, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн 2019, 2020 оны үйл ажиллагааг хамруулан шалгаж, дүгнэлт гаргах, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын 5.1.3, 8.3.15 дахь дэд заалтын хэрэгжилтэд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж ажиллуулах.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо /Б.Жавхлан/-нд даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



Үсгэлдээ ажлаар ажлын үндэсний

Ажлаар ажлын үндэсний

Ажлаар ажлын үндэсний

Ажлаар ажлын үндэсний

Үсгэлдээ ажлаар ажлын үндэсний
Ажлаар ажлын үндэсний

Үсгэлдээ ажлаар ажлын үндэсний
Ажлаар ажлын үндэсний

Үсгэлдээ ажлаар ажлын үндэсний
Ажлаар ажлын үндэсний

Үсгэлдээ ажлаар ажлын үндэсний
Ажлаар ажлын үндэсний

Үсгэлдээ ажлаар ажлын үндэсний
Ажлаар ажлын үндэсний



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 10 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар 133

Улаанбаатар
хот

Журам шинэчлэн батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 38.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1.“Гамшгаас хамгаалах дотоодын хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2.Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Я.Содбаатарт үүрэг болгосугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 29-ний өдрийн 271 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

У.ХҮРЭЛСҮХ

**МОНГОЛ УЛСЫН
ШАДАР САЙД**

Я.СОДБААТАР

Засгийн газрын 2020 оны
133 дугаар тогтоолын хавсралт

ГАМШГААС ХАМГААЛАХ ДОТООДЫН ХҮМҮҮНЛЭГИЙН ТУСЛАМЖИЙГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмын зорилго нь Улсын болон аймаг, нийслэлийн онцгой комисс болон холбогдох төрийн байгууллага гамшгаас урьдчилан сэргийлэх, аврах, гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох үйл ажиллагаанд зориулж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хүмүүнлэгийн тусламж хүсэх, тусламжийг хүлээн авах, бүртгэх, хадгалах, хуваарилах, олгох, тайлагнах, хяналт тавихтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Хүмүүнлэгийн тусламж хүсэх, хүлээн авах, бүртгэх, хадгалах

2.1.Болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшиг, аюулт үзэгдэл, ослын хор уршгийг арилгах, сэргээн босгох, тэмцэхэд улс орны нийгэм, эдийн засгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учирсан

тохиолдолд хүмүүнлэгийн тусламж хүсэх шийдвэрийг улсын хэмжээнд Улсын онцгой комисс, орон нутгийн хэмжээнд аймаг, нийслэлийн Онцгой комисс гаргана.

2.2.Улсын болон орон нутгийн Онцгой комисст ирүүлсэн хүмүүнлэгийн тусламжийн бараа, материал, техник, хэрэгслийг тухайн шатны Онцгой байдлын байгууллага хүлээн авч, бүртгэн түр байршуулж, хадгална.

2.3.Мөнгөн хэлбэрээр үзүүлэх хүмүүнлэгийн тусламжийг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллагын Төрийн сан дахь нэмэлт дансанд төвлөрүүлэн авч, бүртгэнэ.

2.4.Тодорхой байгууллагад нэр зааж ирүүлсэн хүмүүнлэгийн тусламжийг тухайн байгууллага хүлээн авч, бүртгэх, хадгалах ажлыг зохион байгуулах бөгөөд мөнгөн тусламжийг тухайн байгууллагын Төрийн сан дахь нэмэлт дансанд бүртгэнэ.

2.5.Хүмүүнлэгийн тусламжийн тоо хэмжээ, үнэ, чанар, сав, баглаа боодол, үйлдвэрлэгчийн нэр болон хүчинтэй хугацаа зэргийг баримтжуулан бүртгэнэ.

2.6.Улсын болон аймаг, нийслэлийн Онцгой комисст ирүүлсэн хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авсан, хуваарилсан талаарх мэдээллийг тухайн шатны Онцгой байдлын байгууллага нэгдсэн сан байгуулж, хөтөлнө.

Гурав. Хүмүүнлэгийн тусламжийн чанар, стандарт болон түүнийг хадгалахад тавигдах шаардлага

3.1.Хүмүүнлэгийн тусламжийн бараа, материал, техник, хэрэгсэл нь Монгол Улсын хууль тогтоомж, стандарт, хэрэгцээ шаардлагад нийцсэн, хадгалалтын хугацаа нь нийт хадгалах хугацааны 50 хувиас хэтрээгүй байна.

3.2.Хүмүүнлэгийн тусламжийн бараа, материал, техник, хэрэгсэл нь энэ журмын 3.1-д заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд чанар байдалд холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт гаргуулах ажлыг тусламж хүлээн авагч байгууллага хариуцна.

3.3.Хүмүүнлэгийн тусламжийг хуваарилан олгох хүртэлх хугацаанд эрүүл ахуй, чанар, стандартын шаардлага хангасан агуулахад технологийн дагуу хадгална.

3.4. Шаардлагатай тохиолдолд тусламж үзүүлэгчийн агуулахад түр хугацаатай хадгалуулж болох бөгөөд уг агуулах нь энэ журмын 3.3-т заасан нөхцөлийг хангасан байна.

3.5. Хүмүүнлэгийн тусламжийн бараа, материал, техник, хэрэгслийг аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан хадгалуулж болох бөгөөд гэрээнд барааны нэр төрөл, тоо хэмжээ, үнэ, чанар, хадгалах стандарт, хугацаа, төлбөр, талуудын хүлээх үүрэг, хариуцлага, мэдээ, тайлангийн талаар тодорхой тусгана.

Дөрөв. Хүмүүнлэгийн тусламжийг хуваарилах, зарцуулах, хүргэх, олгох

4.1. Хүмүүнлэгийн тусламжийн хэрэгцээ шаардлага, холбогдох байгууллагын саналыг үндэслэн Онцгой байдлын байгууллага хүмүүнлэгийн тусламжийн хуваарилалтыг гаргаж тухайн шатны Онцгой комиссын даргаар батлуулна.

4.2. Хүмүүнлэгийн тусламжийг хуваарилахдаа тэдгээрийг хадгалах тусгай орчин, нөхцөл, хүчинтэй хугацааг харгалзан зохион байгуулна.

4.3. Хүмүүнлэгийн тусламжийг хуваарилсан газарт тээвэрлэн хүргэх, олгох, хяналт тавих ажлыг Онцгой байдлын байгууллага холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

4.4. Энэ журмын 2.4-т заасан хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авсан байгууллагын дарга хэрэгцээ, шаардлагад үндэслэн хуваарилж олгоно.

4.5. Хүмүүнлэгийн тусламж үзүүлэгч тал өөрөө хүссэн тохиолдолд холбогдох зардлыг хариуцан хүмүүнлэгийн тусламжаа хуваарилах, тээвэрлэн хүргэх, олгох ажлыг зохион байгуулж тайланг Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ.

4.6. Хүмүүнлэгийн тусламжийн мөнгөн хөрөнгийг зарцуулах хуваарилалтыг Улсын болон аймаг, нийслэлийн Онцгой комиссын хурлын шийдвэрийг үндэслэн тухайн шатны Онцгой комиссын дарга батална.

4.7. Хүмүүнлэгийн тусламжийн мөнгөн хөрөнгийг гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, тэмцэх, аврах, эрэн хайх, гамшгийн хор уршгийг арилгах, хойшлуулшгүй сэргээн босгох, гамшгаас хамгаалах нөөц бүрдүүлэхээс бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно.

4.8. Шаардлагатай тохиолдолд хүмүүнлэгийн тусламжийг хуваарилах ажилд аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн төлөөллийг оролцуулж болно.

Тав. Хүмүүнлэгийн тусламжийг зохицуулах үйл ажиллагааны зардал, тайлагналт

5.1.Хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хадгалах, хуваарилах, тээвэрлэн хүргэх, олгох үйл ажиллагаатай холбогдон гарах зардлыг тухайн шатны Онцгой комиссын дарга, энэ журмын 2.4-т заасан байгууллагын дарга шийдвэрлэнэ.

5.2.Хүмүүнлэгийн тусламжийн талаарх тайлан, мэдээг улсын хэмжээнд Онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутгийн хэмжээнд аймаг, нийслэлийн Онцгой байдлын байгууллага нэгтгэж, тухайн шатны Онцгой комисст танилцуулна.

5.3.Онцгой байдлын байгууллага болон энэ журмын 2.4-т заасан байгууллага нь хүмүүнлэгийн тусламжийн талаарх тайлан, мэдээг тухайн шатны Онцгой комисст ирүүлж, өөрийн цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тухай бүр мэдээлэх бөгөөд холбогдох байгууллагын шилэн дансанд байршуулна.

5.4.Хүмүүнлэгийн тусламжийн зарцуулалтын тайланд төрийн аудитын байгууллагаар аудит хийлгэнэ.

Зургаа. Бусад

6.1.Энэ журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medeel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 1.5

Индекс: 200003